

# Дөрөвт

Болд тооны хичээлдээ тааруухан. Тэр арифметик прогресс үүсгэдэг дөрвөн бүхэл тоог сонгох болжээ. Өөрөөр хэлбэл дөрвөн тоог эрэмбэлсэн үед хөрш хоёр элемент бүрийн хоорондын зөрөө нь тогтмол байна.

Болд сонголт хийхдээ тоонуудын нэгийг алдсан бөгөөд үлдсэн гурав нь зөв дарааллаар (эрэмбэлэгдсэн) байгаа эсэхийг мэдэхгүй байна.

Үлдсэн гурван тоог өгвөл дөрөв дэх тоог олох программ бичээрэй.

Оролт:

Оролт нь нэг мөрөнд  $-100$ -аас  $100$  хүртэлх завсарт утгатай 3 бүхэл тоог нэг хоосон зайгаар тусгаарлан өгнө. Оролтын өгөгдөл нь үргэлж шийдтэй байх болно.

Гаралт:

Дарааллын дөрөв дэх тоо байж болох нэг тоог гаргаарай. Хоёр хувилбар гарвал их тоог нь сонгоно.

Жишээ:

Оролт1. 4 6 8 Гаралт1. 10

Оролт2. 10 1 4 Гаралт1. 7